



**БАГАХАНГАЙ ДҮҮРГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ**

2025 оны 11 сарын 14 өдөр

Дугаар А/238

Улаанбаатар хот

**“Иргэний андгай өргөх ёслол”-ын арга
хэмжээ зохион байгуулах тухай**

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.2, Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаалын хавсралтын 2.1.5 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Монгол Улсын “Иргэний андгай өргөх ёслол”-ын арга хэмжээнд дүүргийн иргэний үнэмлэх шинээр авах 16 нас хүрсэн иргэдийг 2025 оны 11 дүгээр сарын 25-ны өдөр хамруулахыг Улсын бүртгэлийн хэлтэс (М.Уранцэцэг)-т үүрэг болгосугай.

2. “Иргэний андгай өргөх ёслол”-ын үйл ажиллагаа зохион байгуулах удирдамжийг нэгдүгээр, иргэний үнэмлэх шинээр авах сурагчдын нэрсийг хоёрдугаар, шаардагдах төсвийг гуравдугаар хавсралтаар тус тус баталсугай.

3. Арга хэмжээнд зарцуулагдах 1,990.200 (нэг сая есөн зуун ерэн мянга хоёр зуу) төгрөгийг Засаг даргын нөөц хөрөнгөөс гаргахыг Засаг даргын Тамгын газрын Ерөнхий нягтлан бодогч (С.Баасанхүү)-д зөвшөөрсүгэй.

4. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж, ажиллахыг Засаг даргын орлогч (Х.Цогцэцэг)-т даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



А.СҮХБОЛД

Нийслэлийн Багахангай дүүргийн Засаг даргын
2025 оны 11 сарын 14-ны өдрийн 138 дугаар
захирамжийн нэгдүгээр хавсралт



**“ИРГЭНИЙ АНДГАЙ ӨРГӨХ ЁСЛОЛ”-ЫН
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ УДИРДАМЖ**

Зорилго:

Эх орны ирээдүйн эзэн болох 16 нас хүрсэн сурагчдын төлөөлөлд Монгол улсын иргэн болсныг нь батлах бичиг баримт болох иргэний үнэмлэхийг хүндэтгэлтэйгээр гардуулсанаар тэднийг эх орон түүх соёлоороо бахархах, иргэний үүргээ биелүүлэх ухамсарт иргэн болж төлөвшихөд хувь нэмэр оруулахад оршино.

Хамрах хүрээ:

16 нас хүрч шинээр иргэний үнэмлэхээ гардан авах сурагчид оролцоно.

Зохион байгуулах:

Дүүргийн Улсын бүртгэлийн хэлтэс

Хугацаа, зохион:


2025 оны 11 дүгээр сарын 25-ны өдрийн 10.00 цагт дүүргийн ЗДТГазрын “Хурлын танхим”-д зохион байгуулагдана.

Тавигдах шаардлага:

Оролцох сурагчдын төлөөлөл ёслолын хувцастай байна. /сурагчийн форм/

Зохион байгуулах үйл ажиллагаа:

16 нас хүрсэн сурагчдад Монгол улсын иргэн болсныг нь батлах бичиг баримт болох иргэний үнэмлэхийг хүндэтгэлтэйгээр гардуулан Монгол улсын “Иргэний андгай” өргөнө. Дүүргийн ИТХ-ын дарга, засаг дарга зэрэг удирдлагуудтай дурсгалын зураг авахуулна.



המנהל הכללי

הרשות הבריאות

... (המשלוחים) -

המנהל הכללי של הרשות הבריאות. ... (המשלוחים) - ...

המנהל הכללי של הרשות הבריאות. ... (המשלוחים) - ...

המנהל הכללי של הרשות הבריאות -

Handwritten signature and date

Handwritten signature and date

Handwritten text



מדינת פלשתינה הרשות הבריאות